




## ДИЖИТАЛ ХЭРЭГСЭЛ АШИГЛАН ХҮҮХДЭД УРАН ЗУРАГ ТАНИЛЦУУЛАХ АРГАЧЛАЛ, ҮР ДҮН (Цэцэрлэгт хамрагдсан таван настай хүүхдийн жишээн дээр)

Цэндхүү Золзаяа <sup>а</sup> Доктор (Ph.D), Нацагдорж Хүдэрчулуун<sup>б</sup>  
<sup>а</sup>МУБИС.Сургуулийн Өмнөх Боловсролын Сургууль,  
<sup>б</sup>МУБИС, Багшийн Сургууль

Холбоо барих зохиогч: khuderchuluun@msue.edu.mn  ORCID ID

Хүлээн авсан: 2026.03.12      Хянагдсан: 2026.04.09      Зөвшөөрсөн: 2026.05.18

### Хураангуй

Энэхүү судалгааны зорилго нь дижитал хэрэгсэл ашиглан таван настай хүүхдэд уран зураг танилцуулах аргачлалыг боловсруулж үр дүнг тооцоход чиглэсэн. Судалгаанд хүүхдийн мэдрэх, илэрхийлэх чадвар болон зураг бүтээлийг агуулгаар нь ангилах, гоо зүйн үүднээс үнэлэх чадварыг хөгжүүлэх арга зүйг туршсан болно. Энэхүү арга зүйн хүрээнд интерактив тоглоомд суурилсан сургалт, үйл ажиллагаа, ажиглалт, харилцан яриа, дасгал даалгаврууд орсон. Түүнчлэн хүүхдийн гоо зүйн хөгжлийн түвшин тогтоох үнэлгээний хуудас ашигласан. Өгөгдлийг ажиглалт, харилцан яриа, гүйцэтгэлд суурилсан үнэлгээнд тулгуурлан дүн шинжилгээ хийх аргаар үр дүнг тооцсон. Урлан зурагтай танилцуулах үйл ажиллагаа нь зүгээр нэг “хэлбэр чиг хандлага” биш, харин хүүхдийн мэдрэмж, бодлын төсөөллийг хөгжүүлэх чухал арга юм. Уран зургийн бүтээл нь ерөнхийлсөн бөгөөд нарийвчилсан дүрслэлтэй байдаг тул сургуулийн өмнөх насны хүүхдийн сэтгэл хөдлөл, дотоод ертөнцийг өдөөх онцлог шинж чанартай байдаг. Судалгааны үр дүнгээс харахад хэрэгжүүлсэн арга зүй нь хүүхдийн зүгээс өнгө, хэлбэр, зохиомж зэрэг урлагийн суурь элементүүдийг таних чадвар, мөн мэдрэх, илэрхийлэх чадварт эерэг нөлөө үзүүлсэн байна. Түүнчлэн дижитал хэрэгслүүдийг ашиглах нь хүүхдийн сонирхол, оролцоог нэмэгдүүлдэг болохыг тогтоосон. Судалгааны дүгнэлтээр энэхүү арга зүй нь бага насны хүүхдэд уран зургийн бүтээлийг танилцуулахад үр дүнтэй бөгөөд цаашид сургуулийн өмнөх боловсролын хүрээнд хэрэгжүүлэх боломжтой гэж үзлээ.

### Түлхүүр үг:

Сургуулийн өмнөх боловсрол, урлагийн боловсрол, бүтээлч сэтгэлгээ, зураг урлал

### Удиртгал

Бага насны хүүхдэд дижитал хэрэгсэл (ICT) ашиглан уран зургийн бүтээлтэй танилцуулах аргачлал нь интерактив оролцоог дэмжиж, идэвхгүй ажиглахаас идэвхтэй бүтээлч үйл ажиллагаанд шилжихэд чиглэгддэг. Энэ нь уран зураг ашиглан хүүхдийн гоо зүйн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх зорилготой. Бага насны хүүхдэд танилцуулах уран зургийн бүтээлийг сонгохдоо тэдний хэрэгцээ сонирхол, нас сэтгэхүйн онцлогт тулгуурласан байх ёстой. Бага насны хүүхдэд танилцуулах уран зургийн бүтээлийн төрөл хэлбэр, агуулгын хүрээ, тавигдах шаардлагын талаар судлаач А.В.Бакушинский, К.М.Лепилов, Е.А.Флерина нар өөрийн судалгааны бүтээлдээ тусгайлан авч үзсэн байдаг. Манай улсын хувьд 2025-2026 оны хичээлийн жилээс хэрэгжүүлж байгаа сургуулийн өмнөх боловсролын шинэчилсэн хөтөлбөрийн “Зураг урлал” чиглэлийн “Урлагийн



бүтээл” дэд айд хүүхдэд танилцуулах уран зургийн бүтээлийн агуулгын хүрээг түвшинчлэн суралцахуйн үр дүнгээр тодорхойлсон. Уран зургийн бүтээлтэй танилцуулах үйл ажиллагаа нь зүгээр нэг “хэлбэр чиг хандлага” биш, харин хүүхдийн мэдрэмж, бодол төсөөллийг хөгжүүлэх чухал арга юм. Уран зургийн бүтээл нь өнгө, дүрслэлийн хувьд ерөнхийлсөн бөгөөд нарийвчилсан дүрслэлтэй байдаг тул сургуулийн өмнөх насны хүүхдийн сэтгэл хөдлөл, дотоод ертөнцийг өдөөх онцлог шинж чанартай байдаг. Уран зургийн бүтээлийг танилцуулах нэг хэлбэр нь цахим зургийн цомог бөгөөд үүнд төрөл бүрийн уран зургийн бүтээлүүд багтдаг. Цахим зургийн цомог нь дижитал хэрэгслийн нэг төрөл бөгөөд зураачид уран зургийн агуулга, зураг, чимэглэлийн шийдлийг боловсруулдаг.

Уран зургийн төрөл зүйл (жанр): Франц хэлний жанр (төрөл, зүйл) гэдэг нь уран зургийн сэдэв, дүрслэл, өрнөлийг ихэвчлэн тодорхойлдог. Дүрслэх урлагийн түүхэн хөгжлийн явцад домгийн, шүтээний, түүхэн, дайн тулааны, аж байдлын, байгалийн, хөрөг, амьтны болон натюрморт зэрэг уран зургийн төрөл зүйлүүд бий болсон. Энэхүү ангилал нь ХҮ-ХҮI зуунд бий болсон бөгөөд уран сайхны сэтгэлгээний үе шат бүхэнд нэг нь нөгөөдөө халаагаа өгөх, нөгөө нь шинээр гарч ирэх зэргээр хөгжиж байв. Уран зургийн төрөл зүйлүүдийн зохицлыг уран зургийн бүтээлүүдээс харж болно. Жишээлбэл: Байгалийн уран зураг нь натюрморттой, натюрморт нь байгалийн уран зурагтай хосолж зохицдог бөгөөд төрөл зүйлүүд нь хоорондоо нэвтэршгүй хязгаар заагтай бус харилцан шүтэлцэн хөгждөгийг мартаж болохгүй.

Зургийн сэдвээс хамааран дүрслэх урлагийн бүтээлийг дараах төрлүүдэд хуваадаг.

Зураг 1.



**Үндсэн хэсэг:**

Хүүхдийн хэл яриа бүрэн хөгжөөгүй байх үедээ ч уран зураг дээрх тоглоом, гэрийн тэжээвэр амьтдыг (машин, бөмбөг, эсвэл нохой, муур гэх мэт) таних, заах, нэрлэх зэргээр өөрийн бодол төсөөллөө мэдэрч, илэрхийлж байдаг. Бага насны хүүхэд уран зургуудад сэтгэл хөдлөлөөр хариу үйлдэл үзүүлж, бүтээлийн дүрд орж тоглох зэргээр амьд мэт ярилцдаг. Уран зураг зөвхөн гоо зүйн төдийгүй ёс зүйн чиг баримжаа олгох үүрэгтэй бөгөөд “сайн муу, сайхан муухайгийн” тухай ойлголтыг хүүхдэд таниулдаг. Уран зургийн цахим цомог эдгээр ойлголтыг

харагдахуйц, бодит мэт болгож өгөхөөс гадна хүүхдүүд зургуудыг даган нэгээс нөгөөд шилжиж бодит мэт хүлээн авдаг. Хүүхдийн нас, сэтгэхүй хөгжих тусам уран зургийн утга агуулгыг илүү сайн мэдэрч илэрхийлэхийн зэрэгцээ сонсголын болон харааны ой сайжирч байдаг. Уран зураг нь судалгааны объектын хувьд шинжлэх ухааны олон салбарт судлагддаг. Үүнд:

- Цахим зурагт ном судлалын салбарт О.А.Камкин, Г.М.Коржев, Э.Д.Кузнецов, Ю.Просалкова, Р.М.Ямпольская;
- Урлаг судлал болон утга зохиол судлалд В.Л.Глоцер, В.Н.Горяев, Л.Невлер, А.Т.Сотников;
- Боловсрол судлал – уран зураг танилцуулах арга зүйн судлалд З.Арсентьева, Т.П.Артемяева, Л.И.Беленькая, О.Г.Векслер, О.Кабачек;
- Дүрслэх урлагийн сургалтын арга зүйд уран зургийг урлаг, гоо зүйн үүднээс хүлээн авч мэдэрч илэрхийлэх арга хэрэгсэл болгон ашиглах зорилгоор В.А.Езикеева, Р.И. Жуковская, В.Я.Кионова, Н.А.Курочкина нарын судлаачид ажиллаж байна.

Энэхүү судалгааны ач холбогдол нь хүүхдийн гоо зүйн хөгжил төлөвшилд уран зургийн гүйцэтгэх үүргийг судлах, үр дүнг тооцох явдал юм. Учир нь уран зураг дүрслэх урлагийн бие даасан төрөл болохын хувьд урлаг, гоо зүйн өвөрмөц давуу талтай бөгөөд урлагийн төрөл зүйлүүдээс хүүхдийн танин мэдэхүйд хамгийн чухал нөлөө үзүүлэх хүчин зүйл болдог. Энэ нь дүрслэх урлагийн бусад төрлүүдтэй (зураасан зураг, баримал гэх мэт) танилцах эхний шат болдог [Григорьева, 2000; Комарова, 2005].

Уран зурагтай танилцуулах үйл ажиллагаа нь сургуулийн өмнөх насны хүүхдийг зурах, урлах үйлддэд дадлагажуулах анхдагч үр дүнтэй арга бөгөөд бие даасан, өвөрмөц бүтээлч байдлын жишээ болдог. Хүүхэд уран зургийн бүтээлээс илэрхийлэл ба зураачийн бодол төсөөлөл, дүрслэл хоорондын холбоо хамаарал, дотоод зохицол зэргээс хүүхэд баяр баясгаланг мэдэрдэг. Учир нь уран зураг хүүхдийн гоо зүйн эерэг мэдрэмжийг хөгжүүлдэг бөгөөд сайхны тухай ойлголтыг бүх хүрээнд (ялангуяа ёс зүйн хүрээнд) хүлээн авах хүслээр илэрдэг. Мөн хүүхдийн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, дүрс, өнгө, харьцаа, бүтцийг ойлгоход сургадаг. Цахим зурагт цомгийг зураг дүрслэлийн тусгай арга хэрэгслээр бүтээсэн оюун ухааны тоглоом гэж тодорхойлж болно.

Хүүхдийн зурсан зургууд эхэн үедээ дүрслэл, агуулгын хувьд хязгаарлагдмал байдаг шалтгаан нь тэдний хуулбарлан зурах сэтгэхүйтэй холбоотой учир нэгэн хэвийн хэв маяг үүсдэг. Хүүхдийн зураг дүрслэлд нэгэн хэвийн хэв маяг үүсэх өөр нэг шалтгаан нь уран зурагтай танилцуулах үйл ажиллагаа дутмаг байдалтай холбоотой. Хүүхдийн зураг бүтээлийн агуулгыг илүү баялаг болгохын тулд зохиомжийн арга хэрэгслийг илүү сонголттойгоор ашиглах шаардлагатай байдаг. Зохиомжийн хэрэгсэлд цэг, толбо, зураас, өнгө, дүрс гэх мэт орно. Зохиомжийн хэрэгслийн баялаг, оновчтой сонголт нь бүтээлийн харагдах байдал чухал нөлөө үзүүлдэг. Цэцэрлэгт уран зургийг танилцуулахдаа ихэнхдээ зөвхөн сургалтын хэрэглэгдэхүүн, арга зүйн материал болгон явцуу хүрээнд ашиглаж байгаа бөгөөд хүүхдийн зурах чадварыг хөгжүүлэх, дүрслэх урлагт сургах зорилгоор ашиглахгүй байна.



Бага насны хүүхдэд танилцуулах уран зургийн бүтээлд тавигдах шаардлага: Багш, хүүхдэд танилцуулах зураг бүтээлийг сонгохдоо дараах зүйлийг анхаарах шаардлагатай. Үүнд:

- Хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт нийцсэн
- Танин мэдэхүйг дэмжсэн
- Хэрэгцээ сонирхолд нийцсэн
- Сэтгэл хөдлөлийг дэмжсэн
- Эерэг харилцаа хандлагыг дэмжсэн
- Бүтээлч байдлыг харгалзсан гэх мэт хүүхдийн хөгжилд эерэг нөлөө үзүүлэхүйц бүтээлийг сонгоно.

Практик туршлагаас харахад хүүхдийн урлаг, гоо зүйн боловсролын амжилт нь бүтээлийн сонголтоос хамаардаг. Сургуулийн өмнөх насны хүүхдэд танилцуулах уран зургийн бүтээлийг сонгохдоо тухайн зургийн сэдэв, зураачийн илэрхийлсэн гол санаа, бүтээлийг яагаад бүтээсэн, агуулгыг хэрхэн илэрхийлсэн зэргийг анхаарах шаардлагатай. Үүнд:

- Зураач юу дүрсэлсэн, бүтээлийг юунд зориулсан, бүтээлийн гол санаа, агуулгыг хэрхэн илэрхийлсэн гэдгийг тодорхойлох
- Уран зургийн урсгал чиглэл, нийгмийн үзэгдлийг одоо цагт хэрхэн тусгасан байдал
- Хүрээлэн буй орчин, улирлын хувирал өөрчлөлтийг дүрсэлсэн байдал
- Агуулга (юуг дүрсэлсэн) ба дүрслэлийн арга хэрэгсэл (ямар аргаар дүрсэлсэн) хооронд нэгдмэл ойлголт бий болох
- Өнгөний шийдэл, зохицол, эрс тэс ялгараа
- Зургийн зохиомж
- Өмнө танилцуулсан зургуудтай холбож ойлгох, анхаарал хандуулах нь хүүхдүүдэд урлагийн бүтээлийг мэдрэх, илэрхийлэх түвшинг аажмаар нэмэгдүүлэх боломж олгодог
- Ижил төстэй бүтээлүүдэд амьдралын бодит байдлыг бүтээлчээр илэрхийлсэн байдал
- Бүтээл нь илүү сэтгэл хөдлөм, тод өнгөтэй байх тусам мэдрэмж, ухамсарт илүү хүчтэй нөлөөлдөг гэх мэт зүйлд анхаарал хандуулна.

Хүүхэд ямар төрлийн уран зургийг сонирхдог вэ?

Туршлагаас харахад уран зургийн төрлүүдээс “Хөрөг зураг, аж байдлын сэдэвт зураг” тэдний сонирхолд ихэд нийцдэг. Түүнчлэн хүүхэд уран зурагт хандах хандлагаа товчхон “Надад таалагдсан” гэсэн үгээр тайлбарладаг. Тэд яагаад таалагдсан болохоо тайлбарлахад хэцүү байж болно. Тэдэнд таалагдсан уран зургийг сонгох сэдэл нь ихэвчлэн хийсвэр эсвэл хувийн туршлагаас үүдэлтэй байдаг. Жишээлбэл:

- Эхнийх нь сэтгэл хөдлөл, сэдэл, сонирхлоор тодорхойлогддог хувийн шинж чанартай
- Хоёр дахь нь бүтээлийн агуулга, дүрслэлийг мэдрэх, гоо зүйн үүднээс үнэлэх явдал юм.

Уран зураг танилцуулах явцад хүүхэд уран зургийн агуулга, дүрслэлийн талаарх танин мэдэхүй, гоо зүйн үнэ цэнийг онцолж өгдөг. Танин мэдэхүйн үнэ цэнийг

онцолсноор зураач бүтээлдээ юу илэрхийлснийг тэд төвөггүй ойлгодог. Үр дүнд нь хүүхэд тухайн бүтээлээс мэдэрч, ойлгосон зүйлээ сэтгэл хөдлөлөөр бусдад ярих бөгөөд заримдаа сэтгэл хөдлөлийн хариу үйлдэл нь бүтээлийн өнгөний гоё сайхан зохицлоос үүдэлтэй байдаг. Энэ нь хүүхдийн насны онцлогоор тайлбарладаг.

Багшийн зүгээс хүүхдэд уран зургийн бүтээл танилцуулахад чиглэсэн бэлтгэл: Багш уран зураг танилцуулах сургалт, үйл ажиллагааг зохион байгуулахын тулд уран зургийн талаарх онол, арга зүйн ном, сурах бичиг, гарын авлагатай танилцаж, уншиж судлах. Үүнд:

Үзэсгэлэн, музей үзэх гарын авлага, холбогдох ном, сурах бичиг унших

Зураг урлалын төвийг уран зураг, зурагт үзүүлэн, ном болон бүтээлээр баяжуулах Хүүхдийг уран зургийн бүтээлтэй танилцуулахын өмнө төрөл бүрийн материалаар уралсан цөөн тоот зургийн үзэсгэлэнг урлаг зааланд зохион байгуулах нь илүү үр дүнтэй байдаг. Үзэсгэлэнгийн агуулгыг эцэг, эхийн оролцоотойгоор баяжуулж болно.

Үзэсгэлэнг зохион байгуулсны дараа уран зураг гэж юу болох, хэн зурдаг талаар хүүхдүүдтэй харилцан ярилцана. Жишээ нь: Багш хүүхдүүдээс асуулт асууж: «Уран зураг нь номын зургаас юугаараа ялгаатай вэ?» гэж асууна. Хүүхдүүд хариулж чадахгүй бол багш, уран зураг, номын зургаас хэмжээний хувьд том хэмжээтэй, хананд байрлуулж харж болохыг энгийн байдлаар тайлбарлаж ойлгуулна.

### **Судалгааны арга зүй**

Хүүхдэд уран зураг танилцуулах аргачлал: Хүүхдэд уран зураг танилцуулахын тулд юуны өмнө тэдний үгийн санг нэмэгдүүлэх, харилцан ярилцах, зургийн сэдэвтэй нийцсэн үлгэр, зохиол, дуу, шүлэг, тоглоомын дасгал даалгавруудыг гүйцэтгэх шаардлагатай. Тухайлбал уран зурагтай танилцуулах нь хүүхдээс зөв оновчтой үг, ойролцоо утгатай үгээр урлагийн бүтээлийг тайлбарлах, зүйрлэх, өөрийн мэдрэмж, төсөөллөө илэрхийлэх үгийг сонгох, хэрэглэх чадвартай болоход тусалдаг. Үүнд:


1. Зураг дээр дүрсэлсэн зүйлсийг хэн хамгийн олныг нэрлэж чадах вэ? Асуултын дагуу нэрлэх, ойролцоо утгатай үгээр тайлбарлах.
2. Хүүхдийг зураг дээр дүрсэлсэн хүмүүсийн төлөв байдлыг мэдэрч, ойлгоход дэмжлэг үзүүлэх. (Дохио зангаа, нүүрний хувирал, биеийн хэлэмж). Энэ нь үлгэр, зохиол унших, хүүхэлдэйн театр, кино үзүүлэх, үлгэрийн дүрд тоглох зэргээр дэмжих.
3. Уран зурагт дүрсэлсэн хүмүүсийн дүрийг тодорхойлох, г, дохио зангаа, аялгуугаар илэрхийлэх чадварыг хөгжүүлэх, хүүхдийн мэдрэмж, сэтгэл хөдлөлийг дэмжих.
4. Зураг бүтээлийн талаарх тайлбар яриаг хөгжүүлэхийн тулд “Ямар гоё зураг вэ?”, “Ямар гоё өнгө вэ?” гэсэн хэллэгийг илэрхийлэх дасгалуудыг хийх.
5. Хүүхдийг уран зургийн бүтээлтэй танилцуулахдаа мэргэжлийн үг хэллэгийг ашиглах нь чухал. Энэ нь багшийн зүгээс урлагийн түүхийн мэдлэгтэй байх, зөвхөн энэ төрлийн урлагт хамаарах нэр томъёотой ажиллах чадвартай байхыг шаарддаг.

Урлагийн бүтээлийн талаарх ойлголт нь хүүхдээс зөвхөн тодорхой мэргэжлийн үгийн санг ашиглах, уран зургийн талаарх сэтгэгдлээ логик, уялдаатай илэрхийлэхийг шаарддаг. Хүүхдийг урлагийн бүтээлтэй танилцуулах, ойлгож мэдрэхэд бэлтгэх багшийн чухал нөхцөлүүдийн нэг бол бүлэгт тайван, найрсаг, сэтгэл хөдлөлийн эерэг уур амьсгалыг бий болгох явдал юм.

Хүүхдэд танилцуулах уран зургийн бүтээл:



Зураг 1.



Зураг 2.

### Судалгааны хамрах хүрээ:

Судалгаанд нийслэлийн ЧД-ийн 298-р цэцэрлэгийн бэлтгэл А бүлгийн 35 хүүхэд, Б бүлгийн 37 хүүхдээс эрэгтэй 34, эмэгтэй 38 нийт 72 хүүхэд хамрагдсан. Уран зураг танилцуулах явцад ажиглалт, тэмдэглэл хөтөлж ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулсны үндсэн дээр судалгааны өгөгдөлд математик боловсруулалт хийж, дүгнэлт гаргасан. Хүүхдэд уран зураг танилцуулах үеийн дүрслэх урлагийн бүтээлд үзүүлэх сэтгэл хөдлөлийн хариу үйлдлийг үнэлэх шалгуурыг боловсруулахдаа судлаач Н.В.Шайдуровагийн боловсруулсан хүүхдийн сэтгэл хөдлөлийн хариу үйлдлийг тодорхойлох гүйцэтгэлд суурилсан рубрик үнэлгээний гурван шалгуур үзүүлэлтийг ашиглав. Судалгааны шалгуур үзүүлэлтийн агуулгын шинжилгээг хийхдээ салбарын мэргэжлийн эрдэмтдэд (экспертүүд) танилцуулж санал, зөвлөгөөг тусгаж сайжруулж ажилласан. Энэхүү аргачлал нь 3 шалгуур үзүүлэлттэй бөгөөд шалгуур үзүүлэлт бүрийн үр дүнг хүүхэд тус бүрээр болон хүйсээр нь дүгнэсэн.

### Судалгааны аргачлал:

Туршилт эхлэхийн өмнө хүүхэд бүрд зурагт картыг тарааж өгнө. Багш хүүхдүүдэд уран зургуудыг анхааралтай ажиглахыг хүснэ. Хүүхдэд уран зургийн бүтээлүүдийг агуулгаар нь ангилж өөрт таалагдсан бүтээлээ сонгохыг хүснэ. Сонгосон бүтээлийн талаар ярилцаж асуулт асууж зургийн агуулга, дүрслэлийн тухай ойлголт, мэдрэмж, төрсөн сэтгэгдлийг нь тодруулна. Үүнд: Энэ зураг юуг илэрхийлсэн бэ? Энэ зураг яагаад өөрт чинь таалагдсан бэ? Чиний сонирхлыг юу татсан бэ? Чамд юу бодогдож байна? гэх мэт. Судлаач ажиглалтын тэмдэглэл хөтөлж фото зургаар баримтжуулсан.

### Судалгааны түүвэр:

Түүвэрт сургуулийн өмнөх 4 нас 6 сартайгаас 5 нас 11 сар хүртэлх хүүхдүүд хамрагдсан. Түүврийн тоо  $n=72$ . Түүвэрт хамрагдсан хүүхдийн эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагчаас бичгээр зөвшөөрөл авсан.

Судалгааны түүвэр: Түүвэрт сургуулийн өмнөх 4 нас 6 сартайгаас 5 нас 11 сар хүртэлх хүүхдүүд хамрагдсан. Түүврийн тоо  $n=72$ . Түүвэрт хамрагдсан хүүхдийн эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагчаас бичгээр зөвшөөрөл авсан.

### Судалгааны үр дүн

Диаграмм 1.

Уран зургийг агуулгаар нь ангилж буй байдал


Уран зургийн бүтээлийг агуулгаар нь ангилж өөрт таалагдсан бүтээлээ сонгосон байдлыг авч үзвэл нийт хүүхдийн 34% нь “1-р зураг”, 27% “2-р зураг”-ийг сонгосон бол 39% нь “3-р зураг”-ийг сонгожээ. Энэ нь уг бүтээлийн өнгө зохиомж, дүрслэлийн онцлогоос гадна монгол ахуй соёл үүнд нөлөөлсөн байх магадлалтай.



Диаграмм 2.


Дүрийн сэтгэл хөдлөлийг мэдэрч илэрхийлж буй байдал

Хүүхдүүдийн 45% уран зургийн дүрүүдийн тухай өөрт төрсөн сэтгэгдлээ бусдад ярихын зэрэгцээ би гоё зураг сонгосон болж гэх зэргээр бусдаас магтаал хүсдэг. 37% бүтээлээ тайлбарлан ярьдаг ч дүрүүдийг нэрлэхээс татгалзаж би үүнийг мэдэхгүй гэж асуултад хариулахаас гадна багшаас дэмжлэг хүсэх зэрэг өөртөө итгэлгүй байдал ажиглагдсан. Нийт хүүхдийн 18% нь дүрийн сэтгэл хөдлөлийн талаар хариу үйлдэл үзүүлээгүй.





Диаграмм 3.



Уран зургийг ажиглан өөрт төрсөн сэтгэгдлээ тайлбарлан ярьж буй байдал (хүйсээр

Уран зургийг ажиглан өөрт төрсөн сэтгэгдлээ тайлбарлан ярьж буй байдлыг хүйсээр нь авч үзвэл эмэгтэй хүүхдийн 47% сонгосон зураг бүтээлийн агуулга, дүрслэлийн талаар хүссэн зүйлээ чөлөөтэй тайлбарлан ярьж дүрийн тухай өөрт төрсөн сэтгэгдлээ бусдад илэрхийлэх чадвар илүү байгаа нь ажиглагдсан. Эрэгтэй хүүхдийн хувьд өөрт төрсөн сэтгэгдлээ илэрхийлэх чадвар охидтой ойролцоо байгаа ч цаашид анхаарах шаардлагатай.

Хүснэгт 1.

А, Б бүлгийн сэтгэл хөдлөлийн хариу үйлдлийн ахиц. (E) Count												
Бүлэг	E1-дундаж			гарааны үнэлгээ	E2-дундаж			явцын үнэлгээ	E3-дундаж			эцсийн үнэлгээ
	0.0-1.0	1.1-2.0	2.1-3.0		0.0-1.0	1.1-2.0	2.1-3.0		0.0-1.0	1.1-2.0	2.1-3.0	
А бүлэг	6,6%	31,2%	62,2%	гарааны үнэлгээ	6,6%	31,2%	62,2%	явцын үнэлгээ	0%	4,4%	95,6%	эцсийн үнэлгээ
Б бүлэг	8,9%	48,9%	42,2%		8,9%	48,9%	42,2%		4,4%	37,8%	57,8%	
Нийт оноо	7,8%	53,3%	38,9%		7,8%	53,3%	38,9%		2,2%	36,7%	61,1%	

Туршилтын А бүлгийн гарааны үнэлгээний дээд оноо 62,2% байсан бол явцын үнэлгээ хийхэд ахиц гараагүй. Харин сэтгэл хөдлөлийн хариу үйлдлийн хувьд сургалт, үйл ажиллагааны төгсгөлд эцсийн үнэлгээний дээд оноо 95,6% болж гарааны буюу явцын үнэлгээнээс даруй 33,4 хувиар ахисан. Харин Б бүлгийн гарааны үнэлгээний дээд оноо 42,2% байсан бол явцын үнэлгээ хийхэд мөн ахиц гараагүй. Эцсийн үнэлгээний үр дүн 15,6% ахисан. Хоёр бүлгийн ахицын үнэлгээний дундаж 22,2% ахиц үр дүнг үзүүлсэн байна.

### Дүгнэлт

Судалгааны эцсийн үр дүн нь дижитал хэрэгсэл ашиглан хүүхдэд уран зургийн бүтээл танилцуулах аргачлалыг турших, үр дүнг тооцох явдал байлаа. Хүүхдэд танилцуулах уран зургийн бүтээлд үзүүлэх сэтгэл хөдлөлийн хариу үйлдлийн шалгуур үзүүлэлтүүдийг харьцуулж, шинжлэн судалснаар 4-5 настай хүүхдийн мэдэрч илэрхийлэх чадвар, танин мэдэхүйн хөгжилд илүү шинжлэх ухаанч чиг хандлагыг өгөх болно. Хүүхэд уран зургийн бүтээлийг агуулгаар нь ангилж өөрт

таалагдсан бүтээлээ сонгох, зургийн үйл явдлыг сэтгэл хөдлөлтэйгөөр тайлбарлан ярих, тод баялаг өнгүүдийг сонгож зурах зэргээр сэтгэл хөдлөлөө илэрхийлэх явдал олонтой тохиолддог. Энэ нь гарааны болон явцын үнэлгээ харьцангуй өндөр байх нөхцөлийн нэг болсон. Гэхдээ урлагийн бүтээлд үзүүлэх сэтгэл хөдлөлийн хариу үйлдэл илүү өндөр байх нөхцөл нь хүүхдийг урлагийн бүтээлтэй танилцуулах тэр мөчөөс эхэлдэг. Иймд багшийн зүгээс хүүхдийг уран зурагтай танилцуулах, ажиглалт хийх, сонирхон судлах, тайлбарлан таниулах, уран зураг унших аргад идэвхтэй хөтөлсөн нь урлагийн бүтээлд үзүүлэх сэтгэл хөдлөлийн эцсийн үнэлгээ өндөр байх нөхцөлийн бүрдүүлсэн. Хүүхэд танилцуулж буй бүтээл дээрх зарим зураг дүрслэлийг нэрлэж мэдэхгүй багшаа google-ээс хараач гэх зэргээр танин мэдэхүүд бус цахим технологид илүү их найддаг болсон нь мэдээллийн дижитал эриний нөлөө байж болох юм.

### Талархал

“Дижитал хэрэгсэл ашиглан хүүхдэд уран зураг танилцуулах аргачлал, үр дүн” сэдэвт судалгааны ажлыг хийж гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлсэн Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн 298-р цэцэрлэгийн бэлтгэл А, Б бүлгийн бяцхан багачууд болон, багш, удирдлагуудад талархал илэрхийлье.

### Ном зүй

1. Багдэлгэр, Ж., нар.(2020).*Бага насны хүүхдийн сэтгэл судлал*. Улаанбаатар: “Би Си Ай”
2. Батсайхан Б., & Дэлгэржав, М. (2019). *Боловсрол судлалын тайлбар толь*. Улаанбаатар: Соёмбо принт.
3. БСШУЯ. (2025). *Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөр*. Улаанбаатар:
4. Норжхорлоо, Н. (2001). *Бага насны хүүхдийн хөгжил*. Улаанбаатар: Адмон.
5. Григорьева, Г.Г. (2000). *Развитие дошкольника в изобразительной деятельности*. Москва: Академия.
6. Казакова, Р.Г. (2009). *Занятия по рисованию с дошкольниками*. Москва: ТЦ
7. Казакова, Р.Г. (2006). *Теория и методика развития детского изобразительного творчества*. Москва: Владос
8. Лыкова, И.А. (2013). *Изобразительная деятельность в детском саду. Старшая группа*. Москва:Цветной мир
9. Лыкова, И.А. (2013). *Изобразительная деятельность в детском саду. Подготовительная к школе группа*. Москва: Цветной мир



## Abstract

This study aimed to develop and empirically evaluate a methodology for introducing fine art to five-year-old children through the integration of digital tools. The research examined approaches to fostering children's perceptual and expressive capacities, as well as their ability to categorize artworks by content and assess them from an aesthetic standpoint. The proposed methodology encompassed interactive game-based instruction, structured activities, systematic observation, guided dialogue, and task-based exercises. An aesthetic development assessment rubric was employed to measure children's developmental levels. Data were analyzed through observational records, dialogic interactions, and performance-based evaluations.

Engagement with fine art constitutes not merely a formalistic pedagogical trend, but a substantive means of cultivating imaginative thinking and emotional responsiveness in early childhood. Given that artworks incorporate both generalized and detailed representational elements, they possess a distinctive capacity to stimulate the affective and inner world of preschool-aged children.

The findings demonstrate that the implemented methodology exerted a significant positive effect on children's recognition of foundational artistic elements — including color, form, and composition — as well as on their perceptual and expressive competencies. Furthermore, the integration of digital tools was found to substantially enhance children's motivation and active participation in learning activities.

The study concludes that the proposed methodology proves effective in introducing young children to works of fine art and holds considerable potential for systematic implementation within the broader framework of preschool education